



IX/2022


Тархаасан: 2022 оны 10 дугаар сарын 14



Нас гүйцсэн эр хонины үнэ Дархан-Уул аймагт 242.5 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн 2022 оны 9 дүгээр сарын мэдээллийг өмнөх сартай харьцуулахад атны үнэ 1.4 сая төгрөг болж, 5.3 мянган төгрөгөөр, хязаалан гунын үнэ 1.3 сая төгрөг болж, 1.9 мянган төгрөгөөр тус тус өссөн бол, соёолон үрээний үнэ 1.1 сая төгрөг болж, 11.3 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 205.9 мянган төгрөг болж, 11.0 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 142.3 мянган төгрөг болж, 7.1 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), мянган төгрөгөөр




Эр хонины үнэ 2022 оны 9 дүгээр сард Дархан-Уул аймагт хамгийн их буюу өмнөх сараас 2.5 мянган төгрөгөөр буурч, 242.5 мянган төгрөг, Хэнтий аймагт хамгийн бага буюу өмнөх сараас өөрчлөлтгүй 168.2 мянган төгрөг байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 9 дүгээр сард, мянган төгрөг




Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 9 дүгээр сард 5.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.1 мянган төгрөгөөр, цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ 93.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 7.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 3. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард, төгрөг



Цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ 2022 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 107.5 мянган төгрөг, Булган аймагт хамгийн бага буюу 70.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 4. ЦАГААН НОЛУУРЫН 1 КГ-ЫН ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 9 дүгээр сард, төгрөгөөр



Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 11 дүгээр сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Үнийн статистикийн хэлтсийн статистикч
Г.Ануужин
Утас : (976-51)-261559

